



ХУВАНЦАР ДАХИН БОЛОВСРУУЛДАГ БИЧИЛ, ЖИЖИГ,
ДУНД ҮЙЛДВЭР ЭРХЛЭГЧДЭД ТУЛГАРЧ БУЙ

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ХЯЗГААРЛАЛТЫН ТАЛААРХ СУДАЛГАА

Энэхүү тайланг Европын Холбооны SWITCH-Asia хөтөлбөрийн санхүүжилттэй Монгол Улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд Каритас Чех Репаблик байгууллагын захиалгаар боловсруулан гаргав. Тайланд орсон агуулга нь Европын Холбооны байр суурийг илэрхийлээгүй болно.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	04
ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	04
ӨМНӨХ ҮГ	05
ХУРААНГУЙ	06
01. СУУРЬ СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА БА АРГАЗҮЙ, АРГАЧЛАЛ	07
02. ХУВАНЦАР ДАХИН БОЛОВСРУУЛДАГ БЖДҮЭ-ИЙН САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	08
03. ХУВАНЦАР ДАХИН БОЛОВСРУУЛДАГ БЖДҮЭ-ИЙН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ	09
04. ХУВАНЦАР ДАХИН БОЛОВСРУУЛДАГ БЖДҮЭ-ИЙН САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ХЭРЭГЦЭЭ, ХЯЗГААРЛАЛТ	11
05. ХУВАНЦАР ДАХИН БОЛОВСРУУЛДАГ БЖДҮЭ-ИЙН САНХҮҮ БА КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ	15
06. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ	17
ХАВСРАЛТУУД	18

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуй нэгж
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БЖДҮ	Бичил, жижиг дунд үйлдвэр
БЖДҮЭ	Бичил, жижиг дунд үйлдвэр эрхлэгч
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЖДБЭ	Жижиг дунд бизнес эрхлэгч
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЖДҮГ	Жижиг дунд үйлдвэрийн газар
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан
КЧР	Каритас Чех Репаблик
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмүү өртгийн албан татвар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Диаграм 1.	Бизнесийн зээлийн хэрэгцээ/хувиар/	09
Диаграм 2.	Санхүүгийн менежментийн ур чадвараа хөгжүүлэх хэрэгцээ, /Дундаж (5 бол маш их шаардлагатай, 1 бол огт шаардлагагүй)/	10
Диаграм 3.	Санхүүгийн дэмжлэгийн хэрэгцээ/хувиар/	11
Диаграм 4.	Санхүүгийн болон санхүүгийн бус ямар дэмжлэг шаардлагатай эсэх/хувиар/	11
Диаграм 5.	КОВИД-19 цар тахал бизнест нь нөлөө үзүүлсэн эсэх/хувиар/	15
Диаграм 6.	КОВИД-19 бизнесийн үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөлөл/хувиар/	15
Диаграм 7.	КОВИД-19 цар тахлын эсрэг бизнестээ авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /хувиар/	16
Хүснэгт 1.	Үйл ажиллагааны зардлын дундаж /хувиар/	08
Хүснэгт 2.	Зээлийн хүсэлт болон зээлээ авсан эсэх	09

ӨМНӨХ ҮГ

“Хуванцар дахин боловсруулдаг бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд тулгарч буй санхүүгийн хүртээмж, хязгаарлалтын талаарх” судалгааны ажлыг “Каритас Чех Репаблик”-ийн захиалгаар судлаач Н.Янжинпагма миний бие 2021 оны 10 сарын 01-нээс 2021 оны 11 сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэв.

Энэхүү судалгаа нь Каритас Чех Репаблик (КЧР) болон хамтрагч байгууллагуудын хэрэгжүүлж буй “Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах” төслийн хүрээнд хуванцар дахин боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж байгаа БЖДҮ эрхлэгчдэд үйл ажиллагаагаа явуулахад тулгарч буй санхүүгийн бэрхшээл, санхүүгийн хүртээмжийн хязгаарлалтыг тодорхойлоход чиглэсэн юм.

Судалгааны үр дүн нь хуванцар дахин боловсруулдаг БЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр уг төслийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга замуудыг тодорхойлоход чухал мэдээллийн эх үүсвэр болно гэж итгэж байна.

Энэхүү судалгаагаар Хуванцар дахин боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж байгаа Бичил, жижиг дунд үйлдвэр (БЖДҮ) эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулахад тулгарч буй санхүүгийн бэрхшээл, санхүүгийн хүртээмжийн хязгаарлалтыг тодорхойлохыг зорилоо. Судалгааг тоон аргаар зохион байгуулсан ба судалгаанд 19 БЖДҮЭ-д хамрагдсан.

Хуванцар дахин боловсруулдаг БЖДҮ эрхлэгчдэд үйл ажиллагаагаа явуулахад санхүүгийн ямар бэрхшээл, хязгаарлалт тулгарч байгааг тодорхойлоход макро орчны хязгаарлалт нийтлэг байна. Тухайлбал, хоёрдогч түүхий эд нийлүүлэгч нар ихэвчлэн “хувь иргэн” байдгаас хамааран НӨАТ-н баримт шивж өгдөггүй, үүнээс хамааран үйл ажиллагааны зардлын 20-30%-г эзэлж байгаа түүхий эд, бараа материал худалдан авах зардалд татварын баримтжуулалт хийгдэхгүй байгаа нь ААН-үүдийг татварын өр төлбөр болон эрсдэлд оруулж байна.

Мөн үйлдвэрүүдийн ашиглаж байгаа технологи нь цахилгааны хэрэглээ өндөр байгаагаас өдөр тутмын ашиглалтын буюу урсгал зардал өндөр гардаг байна. Энэ нь үйлдвэрийн үйл ажиллагааны зардлын 10-12%-ийг бүрдүүлж байна. Энэ салбарт ашиглаж байгаа технологи нь цахилгааны зарцуулалт өндөр байхын зэрэгцээ, гар ажиллагаа ихээр шаардаж байгаа нь үйлдвэрүүдийн ашигт ажиллагааг бууруулахад нөлөөлж байна.

Үйлдвэрүүдийн хувьд банк, санхүүгийн байгууллагаас хөнгөлөлттэй зээл авах сонирхол өндөр байна. Гэсэн хэдий боловч Монгол улсад зээлийн бүтээгдэхүүний шаардлага өндөр, хүрэлцээ бага, хүүгийн төлбөр өндөр зэргээс шалтгаалан зээлээр хөрөнгө оруулалт хийх боломж хязгаарлагдмал байна. Тиймээс үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд олон улсын хөрөнгө оруулагчидтай холбогдох, хөрөнгө оруулалт татах сонирхол өндөр байна. КОВИД-19 цар тахлаас үүдэлтэйгээр үйлдвэрлэгчдийн эргэлтийн хөрөнгө, санхүүжилт багассан байна.

Мөн энэ салбарт үйл ажиллагаагаа эхлэхээр болон өргөжүүлэхээр төлөвлөж байгаа 5-н үйлдвэр судалгаанд хамрагдсан. Эдгээр үйлдвэрүүдэд хамгийн шаардлагатай дэмжлэг нь үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх хэмээн тодорхойлж байна. Анхдагч түүхий эдийн гол нийлүүлэгч болох БНХАУ-д КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй үйлдвэрлэлийн хэмжээ буурснаас шалтгаалан тээвэр, түүхий эдийн үнэ болон юанийн ханш өссөн нь түүхий эдийн татан авалтад хүндрэл бий болгож байна. Түүхий эдийн олдоц муу байгаагаас хамааран үйлдвэрүүд түүхий эдийн үнэ хаялцаж авснаар хоёрдогч түүхий эдийн үнийг өсгөх нөхцөл бүрдүүлсэн байна. Өндөр үнэтэй түүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр байгууллагын ашигт ажиллагааг бууруулах үндсэн нөхцөл болж байна. Хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүд түүхий эдийн олдцоос хамааран үйлдвэрийн суурилагдсан хүчин чадлаар үйл ажиллагаагаа явуулж чадахгүй байна.

Дахивар нөөц, хог хаягдлыг бэлтгэн нийлүүлэх тогтолцоо байхгүй байгаагаас түүхий эдийг тээвэрлэх, ангилах, нөөцлөх зардлыг нэмэгдүүлж байна. Ажлын байрны тогтворгүй байдал нь үйлдвэрүүдийн хүний нөөцийн менежментийн зардлыг нэмэгдүүлж байна.

1. СУУРЬ СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА БА АРГАЗҮЙ, АРГАЧЛАЛ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ:

Энэхүү судалгааны ажил нь хуванцар дахин боловсруулдаг БЖДҮ эрхлэгчдэд үйл ажиллагаагаа явуулахад тулгарч буй санхүүгийн бэрхшээл, санхүүгийн хүртээмжийн хязгаарлалт тодорхойлоход чиглэсэн. Үүнд:

“Хуванцар дахин боловсруулах БЖДҮ эрхлэгчдэд тулгарч буй санхүүгийн хүртээмжийн хязгаарлалтын талаарх судалгаа” боловсруулахад шаардагдах мэдээллийг Улаанбаатар хот (18 орчим үйлдвэр) болон Булган аймгийн төв дэх (1 цех) БЖДҮ эрхлэгчдийг хамруулсан

“Хуванцар дахин боловсруулах БЖДҮ эрхлэгчдэд тулгарч буй санхүүгийн хүртээмжийн хязгаарлалтын талаарх судалгаа”-ны тайланг боловсруулсан

СУДАЛГААНЫ ДИЗАЙН:

Тодорхойлон гаргасан зорилтуудыг хангахын тулд тоон арга зүй давамгайлсан, дараалсан холимог арга зүйн дизайныг ашиглав. Судалгааны ажлын хүрээнд тоон мэдээлэл цуглуулан, судалгаанд оролцогчдын хэв шинжийг тодруулан гаргасны дараа тоон дүн шинжилгээний ажлыг гүйцэтгэсэн.

СУДАЛГААНЫ ТҮҮВЭР:

Судалгааг Улаанбаатар хот (18 орчим үйлдвэр) болон Булган аймгийн төв дэх (1 цех) БЖДҮ-ийг хамруулан зохион байгуулсан. Судалгааг оролцогч талуудаас гүнзгийрүүлсэн ярилцлага хийж шинжилгээ хийсэн.

ДҮН ШИНЖИЛГЭЭ, ТАЙЛАН БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ:

Судалгааны мэдээллийн хүрээнд талбараас цугласан мэдээллийг бүрэн оруулж дууссаны дараа тайлан боловсруулах шат эхэлсэн. Судалгааны анхдагч мэдээллийг MS EXCEL программд шивж оруулсан бөгөөд энэ явцад гарах алдааг 2 хувиас хэтрүүлэхгүйг зорьж ажилласан. Санамсаргүй сонголтын аргаар шивж оруулсан мэдээлэл ба бөглөсөн асуулгыг тулгаж шалгасан. Механик болон логик алдаануудыг шалгаж чанарын шаардлагад нийцүүлсний дараа статистик шинжилгээний SPSS 25.0 програмд оруулж, боловсруулалт хийлээ.

Судалгааны мэдээллийн боловсруулалтад сонирхож байгаа үзүүлэлтийн дан тоололтоос гадна харьцуулсан шинжилгээний аргыг өргөнөөр ашиглав. Тухайлбал, түүврийн бүлгүүдийн статистик шинжүүд хоорондоо мэдэгдэхүйц ялгаатай эсэхийг дунджуудыг харьцуулах стьюдентийн t-шинжүүрээр, чанарын хоёр хувьсагчийн хооронд тодорхой мэдэгдэхүйц хамаарал байгаа эсэхийг ки-квадрат шинжүүрээр тус тус шалгасан. Бид эдгээр шинжүүрийг 95 хувийн итгэх түвшинтэй сонгосны үндсэн дээр статистик дүгнэлтүүдээ гаргаж авсан.

2. ХУВАНЦАР ДАХИН БОЛОВСРУУЛДАГ БЖДҮ-ИЙН САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Судалгаанд оролцсон 19 үйлдвэрлэгчээс 18 нь 100 хувь дотоодын хөрөнгө оруулалттай үйлдвэрлэгч бол, 1 нь 100 хувь гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрлэгч хамрагдсан. Үйлдвэрлэгчдийн дийлэнх нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа хог хаягдал цуглуулах цэгүүд болон орон нутгаас түүхий эдээ татан авч байна. Судалгаанд хамрагдсан үйлдвэрлэгчид бүгд бизнесийн орлого, зарлагаа хөтөлдөг, санхүүгийн тайлан гаргадаг, ажилчдынхаа цалингаас НДШ төлдөг, байгууллагын бизнесийн данстай байна. Харин судалгаанд оролцсон 19 байгууллагаас 16-н байгууллага НӨАТ төлөгчөөр бүртгүүлсэн бол, төрийн, олон улсын болон бусад байгууллагаас зарласан төсөл, хөтөлбөрт 3 байгууллага хамрагдсан, үйлдвэрийн байр болон бүтээгдэхүүнээ даатгуулсан эсэхийг тодруулахад 6 байгууллага даатгалд хамрагдсан байна

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО:

Судалгаанд хамрагдсан аж ахуй нэгжүүдээс 8 (42%) нь ашигтай ажиллаж байгаа бол, 1 (5%) нь ашиггүй, 10 (53%) нь ашиг ч үгүй, алдагдал ч үгүй үйл ажиллагаа явуулж байна. Үйлдвэрлэгчид илүү гарсан ашгаа бизнестээ хөрөнгө оруулалт хийх, түүхий эд, бараа материалын татан авалт болон үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх чиглэлд голлон ашигладаг байна. Үйлдвэрлэгчдийн ашигт ажиллагааны дундаж 15 хувь ба 10-20%-ийн хооронд хэлбэлзэж байна. Үйлдвэр ашиггүй ажиллаж байгаа тохиолдолд зөрүүг нь зээлээр голлон санхүүжүүлж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЛАГА:

Хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааны зардлын дундаж зардлыг ангиллаар тооцоход 34.4% цалин урамшуулал, 24.2% түүхий эд, бараа материалын татан авалт, 11.1% ашиглалтын зардал (цахилгаан, ус, интернет, түрээс), 8.8% татвар, 6% зээлийн эргэн төлөлт, 4.5% тээврийн зардал, 4.1% ажлын байрны түрээс, 3.7% тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн зардал, 2.8% хуримтлалд зарцуулж байна.

УТГУУД	АШИГЛАЛТЫН ЗАРДАЛ (ЦАХИЛГААН, УС, ИНТЕРНЕТ, ТҮРЭЭС)	ЦАЛИН, УРАМШУУЛАЛ	ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ	ХУРИМТЛАЛ	АЖЛЫН БАЙРНЫ ТҮРЭЭС	ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТЕХНОЛОГИ	ТЭЭВЭР (БЕНЗИН, ТЭЭВЭРЛЭЛТИЙН ХӨЛС)	ТҮҮХИЙ ЭД, БАРАА МАТЕРИАЛ	ТАТВАР
ДУНДАЖ	11.1	34.4	6	2.8	4.1	3.7	4.5	24.2	8.8
МЕДИАН	11	35	6	2	4	4	5	25	10
ХАМГИЙН ДАВТАГДСАН УТГА	10	35	5	-	4	4	5	26	10
ХАМГИЙН БАГА УТГА	10	32	4	-	-	3	2	15	5
ХАМГИЙН ДЭЭД УТГА	15	37	10	8	7	6	10	28	10

Хүснэгт 1. Үйл ажиллагааны зардлын дундаж /Хувиар/

3. ХУВАНЦАР ДАХИН БОЛОВСРУУЛДАГ БЖДҮ-ИЙН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ


Судалгаанд нийт 19 хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрээс 18 нь зээл авах хүсэлт гаргасан ба үүнээс 13 зээлээ авч чадсан бол, 5 нь зээл авч чадаагүй байна. Зээлээ авч чадаагүй шалтгааныг тодруулахад хүү багатай зээлийн хэмжээ дууссан тул зээл авах хүсэлтээ зогсоосон, орлого тасалдсан тул банкнаас татгалзсан, зээлийн шаардлага хангаагүй, жилийн орлого хүссэн зээлийн хэмжээнд хүрэлцээгүй зэрэг шалтгааны улмаас зээл авч чадаагүй байна. Зээл авах хүсэлт гаргаагүй 1 байгууллага нь хэмээн 100% Хятадын хөрөнгө оруулалттай компани байна. Хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдийн тухайд төрөөс хэрэгжүүлж байгаа бага хүүтэй хөнгөлөлттэй зээл авах сонирхолтой байдаг ч хүнд сурталтай, олдоц бага байдаг байна.

ЗЭЭЛ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАСАН ЭСЭХ	ТОО	ЗЭЭЛЭЭ АВЧ ЧАДСАН ЭСЭХ	ТОО
ТИЙМ	18	ТИЙМ	13
ҮГҮЙ	1	ҮГҮЙ	5

Хүснэгт 2. Зээлийн хүсэлт болон зээлээ авсан эсэх

Зээл авах хүсэлт гаргасан хүмүүсийн 77.8% арилжааны банк, 22.2% банк бус санхүүгийн байгууллага, 5.6% технологи суурьтай санхүүгийн байгууллага, 27.8% ЖДҮГ-н зэрэг төрөөс үзүүлэх хөнгөлөлттэй зээл байна. Байгууллагуудын хувьд бизнесийн зээл авч байгаа зорилгыг тодорхойлоход 72.2% нь тоног төхөөрөмжөө сайжруулах болон худалдан авах зорилгоор авдаг бол, 33.3% нь бизнесийн өдөр тутмын хэрэгцээг хангах, 33.3% ажлын байраа өргөтгөх, худалдах гэсэн зорилгын хүрээнд зээл авсан байна.

Хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэгчдийн **хувьд бага хүүтэй, хугацаа урт, барьцаа хөрөнгийн шаардлага бага зээлийн бүтээгдэхүүний хэрэгцээ өндөр** байна.



Диаграм 1. Бизнесийн зээлийн хэрэгцээ /Хувиар/

Хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдээс санхүүгийн менежментийн ямар төрлийн ур чадварыг хөгжүүлэх хэрэгцээ тодорхойлоход:

- I. Зээлд хамрагдахад тавигдах шаардлага, материал хэрхэн бүрдүүлэх
- II. Эрсдэл, хямралын удирдлага

III. Татварын тайлан гаргах

IV. Бизнес эрхлэхэд төрөөс авдаг татвар, хураамжуудыг талаарх цэгцтэй мэдлэг

олж авах хэрэгцээ хамгийн их байгаа хэмээн тодорхойлсон байна.




Диаграм 2. Санхүүгийн менежментийн ур чадвараа хөгжүүлэх хэрэгцээ
Дундаж /5 бол маш их шаардлагатай, 1 бол огт шаардлагагүй/

Үйлдвэрлэгчдийн хувьд бизнес, санхүүгийн менежментийн ур чадвараа ахиулах зорилгоор жилдээ нэг удаа сургалтад хамрагдах тохиолдол нийтлэг байна.

4. ХУВАНЦАР ДАХИН БОЛОВСРУУЛДАГ БЖДҮ-ИЙН САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ХЭРЭГЦЭЭ, ХЯЗГААРЛАЛТ

Хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэгч нарт санхүүгийн дэмжлэгийн хэрэгцээ байгаа эсэхийг тодруулахад 70% маш их, 5% их, 15% дунд зэрэг, 10% бага шаардлагатай гэсэн хариултыг өгч байна.



Диаграм 3. Санхүүгийн дэмжлэгийн хэрэгцээ /Хувиар/

Мөн судалгаанд оролцогчдоос ямар төрлийн дэмжлэг шаардлагатай байгаа эсэхийг тодруулахад давтагдсан байдлаар 63.2% тоног төхөөрөмжийн дэмжлэг, 57.9% хэрэглээний зардлын хөнгөлөлт, 47.4% бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүн, 36.8% ажлын байрны дэмжлэг, 31.6% буцалтгүй тусламж, 31.6% хөрөнгө оруулалтын дэмжлэг шаардлагатай хэмээн тодорхойлсон байна.



Диаграм 4. Санхүүгийн болон санхүүгийн бус ямар дэмжлэг шаардлагатай эсэх /Хувиар/

Үйлдвэр эрхлэгч нарт зориулсан тоног төхөөрөмжөө шинэчлэх бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүн шаардлагатай байна. Үйлдвэрүүд хүчин чадал бүхий тоног төхөөрөмжтэй болсноор ажиллах хүчний хомсдол болон үйлдвэрийн суурилагдсан бүрэн хүчин чадлаар нь ашиглах боломж бүрдэх юм.

Энэ төрлийн үйлдвэр эрхлэгчдийн ашиглаж байгаа тоног төхөөрөмж нь цахилгаан зардал болон эвдрэл гэмтэл ихтэй байдгаас шалтгаалан хэрэглээний зардал өндөр байна. КОВИД-19 цар тахлын үеийн хэрэглээний зардлын хөнгөлөлт нь байгууллагын үйл ажиллагаанд ихээхэн дэмжлэг болж байгааг онцолж байсан.

ОУБ болон төрөөс хэрэгжүүлж байгаа бага хүүтэй, хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээнд хамрагдах хүндрэлтэй байгааг онцлохын зэрэгцээ авилгал, хүнд суртал байгааг тэмдэглэж байсан.

Судалгаанд хамрагдсан хуванцар хог хаягдал дахин үйлдвэрүүдэд дараах санхүүгийн болон санхүүгийн бус хязгаарлалтууд үйл ажиллагаанд нь үүсэж байна. Үүнд:

ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨ

Хуванцар хог хаягдал дахин боловсруулан эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг

хэмнэн хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулж байгаанийгэм, эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан татварын бодлогоор дэмжих шаардлага байна. Мөн хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдэд хоёрдогч түүхий эд нийлүүлэгч нар ихэвчлэн “хувь иргэн” байдгаас хамааран НӨАТ-н баримт шивж өгдөггүй, **үүнээс хамааран үйл ажиллагааны зардлын 20-30%-г эзэлж байгаа түүхий эд, бараа материал худалдан авах зардалд татварын** баримтжуулалт хийгдэхгүй байна. Гэвч эдгээр үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүдийг НӨАТ-н баримт шивэх болон татварыг төлөх үүрэг хүлээж байгаа нөхцөл нь аж ахуй нэгжүүд албан татварын тайлангаа худал, буруу ташаа мэдээлэх нөхцөлийг үүсгэхийн зэрэгцээ татварын төлбөрт оруулж байна. Олон улсын туршлагаас авч үзвэл хуванцар хог хаягдлыг боловсруулан эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэн хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах чиглэлд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдийг татвараас чөлөөлөх болон хөнгөлөх туршлагауд түгээмэл байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ӨСӨЛТ:

Хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдийн ашиглаж байгаа технологи нь цахилгааны хэрэглээ өндөр байгаагаас өдөр тутмын ашиглалтын буюу урсгал зардал өндөр гардаг байна. Энэ нь үйлдвэрийн үйл ажиллагааны зардлын 10-12%-ийг бүрдүүлж байна. Сүүлийн нэг жилийн хугацаанд КОВИД-19 цар тахлын нөлөөг бууруулах арга хэмжээний хүрээнд ААНБ-уудын хэрэглээний зардлыг хөнгөлсөн нь цар тахлыг даван туулахад бодитоор үзүүлсэн дэмжлэг болж чадсан байна. Гэвч энэхүү КОВИД-19 цар тахлын үеийн хөнгөлөлт дуусгавар болсноор аж ахуй нэгжүүдийг үйл ажиллагааны зардалд ихээр нөлөөлөх зардал хэмээн тодорхойлж байна. Олон улсын туршлагаас авч үзвэл хуванцар хог хаягдал дахин боловсруулдаг БЖДҮ эрхлэгчдийн хувьд цахилгаан буюу хэрэглээний зардалд тарифын хөнгөлөлт эдлүүлэх болон үнэ тарифыг тодорхой хугацаанд тогтворжуулах дэмжлэг үзүүлдэг ба судалгаанд хамрагдсан байгууллагуудын хувьд шаардлагатай байгааг онцолж байна.

ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ, САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДУТАГДАЛ:

Хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдэд чиглэсэн тогтвортой санхүүжилт, хөнгөлөлттэй зээл, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дэмжин хөгжүүлэх шаардлага байна. Үйлдвэрүүдийн хувьд банк, санхүүгийн байгууллагаас хөнгөлөлттэй зээл авах сонирхол өндөр байна.

ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ГААЛЬ, НӨАТ-ААС ЧӨЛӨӨЛӨХ:

Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн хувьд тулгамдаж байгаа нэг асуудал нь техник, тоног төхөөрөмжийн эвдрэл болон сэлбэг олдоц муу байдал байна. Мөн энэ салбарт үйл ажиллагаагаа эхлэхээр болон өргөжүүлэхээр төлөвлөж байгаа 5-н үйлдвэр судалгаанд хамрагдсан. Эдгээр үйлдвэрүүдэд хамгийн шаардлагатай дэмжлэг нь үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх хэмээн тодорхойлж байна. Тухайлбал хуванцар хог хаягдал дахин боловсруулах техник, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийг гаалийн татвараас чөлөөлөгдөх барааны жагсаалтад оруулж гааль, НӨАТ-ийн албан татвараас чөлөөлөх шаардлага байна.

ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ:

КОВИД-19 цар тахлаас өмнө валютаар зээл авсан 1 аж нэгж судалгаанд хамрагдсан ба зээлийн эргэн төлөлт хийхэд хүндрэлтэй байгааг онцолж байсан. Мөн юанийн ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан анхдагч түүхий эдийн татан авалт хийхэд санхүүгийн хувьд хүндрэл бэрхшээлтэй байгааг онцолж байсан. Анхдагч түүхий эдийн гол нийлүүлэгч болох Хятад улсад КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй үйлдвэрлэлийн хэмжээ буурснаас шалтгаалан түүхий эдийн үнэ өсөхийн зэрэгцээ, юанийн ханш өссөн нь түүхий эдийн татан авалтад хүндрэл бий болгож байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

Үйлдвэрлэгчдийн хувьд үйлдвэрлэлээ өргөтгөх, тоног төхөөрөмжөө шинэчлэх төлөвлөгөө байна. Гэсэн хэдий боловч Монгол улсад зээлийн бүтээгдэхүүний шаардлага өндөр, хүрэлцээ бага, хүүгийн төлбөр өндөр зэргээс шалтгаалан зээлээр хөрөнгө оруулалт боломж хязгаарлагдмал байна. Тиймээс үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд олон улсын хөрөнгө оруулагчидтай холбогдох, хөрөнгө оруулалт татах сонирхол өндөр байна. Мөн энэ чиглэлийн хөрөнгө оруулалт татах, зуучлах үйлчилгээнд хамрагдах сонирхол өндөр байна.

ТҮҮХИЙ ЭД МАТЕРИАЛЫН ОЛДОЦ БА ҮНЭ:

Түүхий эдийн олдоц муу байгаагаас хамааран үйлдвэрүүд үнэ хаялцаж авснаар хоёрдогч түүхий эдийн үнийг өсгөх тохиолдол байна. Өндөр үнэтэй түүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр байгууллагын ашигт ажиллагааг бууруулах үндсэн нөхцөл болж байна. Мөн КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй иргэдийн хэрэглээ багасаж байгаагаас хамааран түүхий эдийн олдоц буурч байгаа байдал ажиглагдаж байна.

ХОГ, ХАЯГДЛЫН ТАЛААРХ ТӨРИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ОНОВЧТОЙ БОЛГОХ:

Хуванцар хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг буюу хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, ААНБ-д эдийн засгийн урамшуулал олгох тогтолцоог бий болгох шаардлага байна. Учир нь хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүд түүхий эдийн олдцоос хамааран үйлдвэрийн суурилагдсан хүчин чадлаар үйл ажиллагаа явуулж чадахгүй байна. Энэхүү нөхцөл үйлдвэрүүдийг өргөжих, үйл ажиллагаа төрөлжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

ИРГЭДИЙГ МЭДЭЭ, МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ:

Монгол улсын хэмжээнд дахивар нөөц буюу дахин ашиглагдах, дахин боловсруулах, сэргээн ашиглагдах хог хаягдлыг бэлтгэн нийлүүлэх тогтолцоо бүрдээгүйгээс үйлдвэрүүдэд түүхий эд олдоц муу байна. Үүнээс үзвэл ангилан ялгах, татан авах системийг бий болгох шаардлага байна. Дахивар нөөц, хог хаягдлыг бэлтгэн нийлүүлэх тогтолцоо байхгүй байгаагаас түүхий эдийг тээвэрлэх, ангилах, нөөцлөх зардлыг нэмэгдүүлж байна.

АЖИЛЧДЫН ЦАЛИН ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ:

Дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрүүдийн хувьд мэргэжилтэй, мэргэшсэн ажиллах хүчин, хүний нөөцийн хомсдол байна. Дахин боловсруулах үйлдвэрийн салбарт ажиллагсад нь хөдөлмөрийн хортой, хүнд нөхцөлд ажиллаж байна. Ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, нийгмийн баталгааг хангах шаардлагатай байна. Ажлын байрны тогтворгүй байдал нь үйлдвэрүүдийн хүний нөөцийн менежментийн зардлыг нэмэгдүүлж байна.

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТЫН СУРГАЛТ, МЭРГЭЖИЛТНЭЭР ДЭМЖИХ:

Дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбарт инновацид суурилсан дэвшилтэт техник, технологи, өндөр технологийг нэвтрүүлэх замаар үр ашгийг нэмэгдүүлэх хэрэгцээ байна. Энэ салбарт ашиглаж байгаа технологи нь цахилгааны зарцуулалт өндөр байхын зэрэгцээ, гар ажиллагаа ихээр шаардаж байгаа нь үйлдвэрүүдийн ашигт ажиллагааг бууруулахад нөлөөлж байна.

ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ:

КОВИД-19 цар тахлын нөлөөнөөс хамааран үйлдвэрүүд ашиггүй ажиллаж байгаагаас хамааран жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байх нөхцөл бүрдсэн ба үүний улмаас цагаан сарын баяраас үүдэлтэй түүхий эдийн нийлүүлэлт нэмэгдэх үед түүхий эдээ нөөцөлж авч чадахгүй байх үндсэн нөхцөл бүрдэж байна.

ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ:

Үйлдвэрүүдийн хувьд хамтарсан татан авалт хийх, түүхий эдийн хамтарсан агуулах байгуулах боломжийг эрэлхийлсэн тохиолдолд түүхий эдийн нөөцөөс хамааралтай байдлыг бууруулах боломж байгааг онцолж байсан.

СТАНДАРТ БОЛОВСРУУЛАХ:

Үйлдвэрүүдийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнд стандарт байхгүйгээс хамааран чанар харилцан адилгүй байгааг тэмдэглэж байсан. Тиймээс үйлдвэрүүдийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгох, гарал үүслийн гэрчилгээ олгох шаардлага байна.

ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ:

Монголд үйлдвэрлэж байгаа болон үйлдвэрлэх боломжтой бүтээгдэхүүн гаднаас орж ирсэн тохиолдолд гаалийн өндөр татвар тогтоох шаардлага байна. Импортын бүтээгдэхүүн дээр гаалийн өндөр татвар тогтоох шаардлага байна.


ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ОРЧИНГ САЙЖРУУЛАХ:

Эко төлбөрийн тухай хуулийг баталж хуванцар хог хаягдал дахин боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-уудыг дэмжих шаардлагатай байна.

5. ХУВАНЦАР ДАХИН БОЛОВСРУУЛДАГ БИЧИЛ, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙН САНХҮҮ БА КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ

Судалгаанд хамрагдсан нийт үйлдвэрүүдийн бизнесийн үйл ажиллагаанд КОВИД-19 цар тахал 57.9%-д нь маш их нөлөөлсөн гэсэн бол, 26.3% нь дунд зэрэг нөлөөлсөн хэмээн үзсэн. Улс хоорондын хөдөлгөөнийг зогсоож, хил хаах, хөл хорио тогтоох зэрэг арга хэмжээ авсны улмаас үйлдвэрүүд бараа материал, түүхий эдээ татаж чадахгүй байх, эргэлтийн хөрөнгөгүй болох, бараа бүтээгдэхүүний олдоц муу байх, түүхий эд, материалын үнэ өсөх, ажилтнуудынхаа цалинг тавьж чадахгүй байх зэрэг хүндрэлүүдтэй тулгарч, бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломж хязгаарлагдмал байжээ.

Харин ҮСХ-с 2021 оны 2-р сард 2404 ААН-үүдийг судалгаанд хамруулахад нийт судалгаанд оролцогчдын 71.1% нь “Санхүүгийн байдал хүндэрсэн” гэж хариулжээ. Мөн үйл ажиллагаа нь хүндэрч “орлого буурсан” ААН-ийн 61% нь бизнесийн үйл ажиллагааны орлогоо 50%-аас дээш буурсан гэж үзсэн^[1] нь уг судалгааны үр дүнтэй ойролцоо байна.



Диаграм 5. КОВИД-19 цар тахал бизнест нь нөлөө үзүүлсэн эсэх /Хувиар/

Судалгаанд оролцогчид 78,9% бараа материал, түүхий эд бүтээгдэхүүний олдоц муу, 78,9% бараа материал, түүхий эд бүтээгдэхүүний үнэ өссөн, 73.7% эргэлтийн мөнгө, санхүүжилт багассан, 57.9% хөл хорионоос үүдэлтэй үйл ажиллагаагаа түр зогсоосон гэсэн хариултуудыг өгчээ. Үүнээс харахад үйлдвэрлэгчдийн хувьд түүхий эдийн олдоц, түүхийн эдийн үнийн өсөлт, эргэлтийн хөрөнгө болон санхүүгийн асуудал хамгийн том бэрхшээл байсаар байна.

Тэгвэл КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах, бизнесийн үйл ажиллагаагаа эрсдэл багатайгаар даван туулах зорилгоор судалгаанд оролцсон бизнес эрхлэгчид дараах арга хэмжээнүүдийг авсан байна. Тэдний 47.7% арилжааны банк, ББСБ, хувь хүмүүсээс нэмж өр зээл тавьсан, 36.8% хувийн хадгаламжаа ашигласан, 21.1% бизнесийн зарим хөрөнгийг зарсан гэх мэт арга хэмжээнүүдийг авсан байна.

Хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн салбарт КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй дараах 2 нөхцөл байдал үүссэн байна. Үүнд:



Диаграм 6. КОВИД-19 цар тахлын эсрэг бизнестээ авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /Хувиар/

[1] Үндэсний статистикийн хороо. ААН-ийн үйл ажиллагаанд корона вируст халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөлөл. 2021



Диаграм 7. КОВИД-19 бизнесийн үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөлөл /Хувиар/

ТҮҮХИЙ ЭД МАТЕРИАЛЫН ОЛДОЦ БА ҮНИЙН ӨСӨЛТ:

ҮСХ-ны мэдээллээс үзвэл КОВИД-19 цар тахлаас үүдэлтэйгээр хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 2.4 хувь, өмнөх сараас 1.0 хувиар өсөв. Үүний 2.2 нэгж буюу 91.7 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Өрхийн сарын дундаж нийт орлого, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 1.1 сая төгрөг болж өмнөх улирлаас 75.5 (6.2%) мянган төгрөгөөр буурчээ. Өрхүүдийг мөнгөн орлогоор бүлэглэхэд, 300 мянган төгрөг хүртэлх орлого бүхий өрх өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.9 пунктээр буюу 8.6 мянган өрхөөр нэмэгдсэн байна. Энэ нь цар тахлын нөлөөлөл нийгмийн хамгийн эмзэг бүлэгт хүндээр тусч байгааг илтгэж байна².

Иргэд олон нийтийн хэрэглээ буурсантай холбоотойгоор түүнийг даган бий болдог түүхий эд нөөц буурсан байна. Түүхий эдийн нөөцийн хомсдол бий болсонтой холбоотойгоор түүхий эдийн үнийн өсөлт зах зээл дээр явагдсан байна. Мөн үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүдийн хувьд эргэлтийн хөрөнгө, бэлэн мөнгөний хомсдолоос үүдэлтэй түүхий эдийн татан авалт тасалдах болон, түүхий эдээ нөөцлөх боломж хязгаарлагдсан байна. Түүхий эдийн үнэ 25-35%-иар өссөн байна.

ТЭЭВЭРЛЭЛТ:

КОВИД-19 цар тахал болон хилийн хөл хорионоос шалтгаалан тээврийн болон шатахууны үнэ өссөн нь анхдагч түүхий эдийг татан авалтад ихээхэн хүндрэл учруулж байна. Тээврийн зардал өмнөх оны мөн үеэс 10 дахин өссөн хэмээн судалгаанд оролцогчид хэлж байна. Манай улсын нийт импортын 50%-ийг нэвтрүүлдэг, БНХАУ-тай хиллэдэг хамгийн том боомт болох Замын-Үүдэд хэвийн үед хоногт 250 машин нэвтэрдэг байсан бол дотооддоо халдвар тархаж, Дорноговь аймагт эерэг тохиолдол бүртгэгдсэнээс шалтгаалан хоногт 50 машин нэвтэрдэг болж буурч, хил хоорондын тээврийн үнэ 10 дахин өссөн. Эрээн боомтын ачаалал хэтэрч БНХАУ-аас авах ачаа татан авалтыг багасгасан, Замын-Үүд дэх машины тоо 5000 давсан. Өнөөдрийн байдлаар хөл хорио тогтоож, Эрээний боомт таг гацсан нөхцөл байдал үүссэн.

[2] Үндэсний статистикийн хороо. Коронавирус ба эдийн засаг. BookLibraryDownload.ashx (1212.mn)

6. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ (БЖДҮ)

Хуванцар дахин боловсруулдаг БЖДҮ эрхлэгчдэд үйл ажиллагаагаа явуулахад санхүүгийн ямар бэрхшээл, хязгаарлалт тулгарч байгааг тодорхойлоход макро орчны хязгаарлалт нийтлэг байна. Тухайлбал, татварын орчин, хэрэглээний үнийн өсөлт, валютын ханшийн өөрчлөлт, тоног төхөөрөмжийг гаалийн татвар, хураамж, түүхий эд материалын үнийн өсөлт зэрэг хязгаарлалт нийтлэг байна. Эдгээр хязгаарлалтыг даван туулахад хууль эрх зүйн орчинг сайжруулахын зэрэгцээ, хог хаягдлыг ангилан, ялгах тогтолцоог системийн хувьд зөв төлөвлөх, шийдвэрлэх шаардлага байна.

Судалгаанд хамрагдсан аж ахуй нэгжүүдээс 8 (42%) нь ашигтай ажиллаж байгаа бол, 1 (5%) нь ашиггүй, 10 (53%) нь ашиг ч үгүй, алдагдал ч үгүй үйл ажиллагаа явуулж байна. Мөн эдгээр бизнес эрхлэгчдийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх шаардлага байна. Ашигт ажиллагаа бага нь үйлдвэрт ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийг суурилагдсан хүчин чадлаар ашиглахгүй байх болон тоног төхөөрөмжийн хэрэглээний зардал өндөр байх, хүний хүчин зүйлсээс хэт хамааралтай байх, ажиллах хүчний тогтвор суурьшилтай байдлаас хамааралтай байна. Тиймээс энэ салбарт мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх болон тоног төхөөрөмжийн шинэчлэлийг эрчимжүүлэх шаардлага байна.

Хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэгчдийн хувьд бага хүүтэй, хугацаа урт, барьцаа хөрөнгийн шаардлага бага зээлийн бүтээгдэхүүний хэрэгцээ өндөр байна. Үйлдвэрлэгчдийг банк, санхүүгийн байгууллагатай холбох, тусгайлсан ногоон зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох хэрэгцээ байна.

Мөн хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэгчдийн хувьд КОВИД-19 цар тахлаас шалтгаалан түүхий эд материалын олдоц хомсдол, үнийн өсөлт болон тээвэрлэлтийн нөхцөлөөс шалтгаалан санхүүгийн хязгаарлалтад өртөж байгаа байдал нийтлэг байна.

ХАВСРАЛТУУД

Каритас Чех Репаблик (КЧР) нь Европын Холбооноос санхүүжүүлж буй “Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах” нь төслийн хүрээнд “Хуванцар дахин боловсруулдаг бичил, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд тулгарч буй санхүүгийн хүртээмжийн хязгаарлалтыг тодорхойлож” судалгааг зохион байгуулж байна. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн төслийн цаашдын ажил төлөвлөгдөх учраас судалгаанд идэвхтэй оролцож, үнэн зөв мэдээллээр хангахыг танаас хичээнгүйлэн хүсье. Бид таны өгсөн мэдээллийн нууцыг холбогдох бүх хууль, дүрмийн дагуу чандлан хадгалах бөгөөд зөвхөн судалгааны зорилгоор ашиглана. Хэрэв таныг зөвшөөрвөл, бид судалгааны чанарыг хянах зорилгоор, энэхүү яриаг бичлэгт хурааж авах юм. Хэрэв та бичлэг хийлгэхийг хүсэхгүй бол бидэнд мэдэгдээрэй.

№	АСУУЛТ	ХАРИУЛТ		
1	Танай байгууллагын нэр			
2	Судалгаанд оролцогчийн мэдээлэл			
3	Судалгаанд оролцогчийн холбоо барих мэдээлэл			
БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ				
4	Танай байгууллагын жилийн борлуулалтын орлого хэдэн төгрөг байдаг вэ?	ЖИЛ	БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	
		2019		
		2020		
		2021		
5	Таны бизнес ашигтай ажиллаж чаддаг уу?	1. Тийм % 2. Үгүй% 3. Ашиг ч үгүй, алдагдал ч үгүй таардаг		
6	Ашигтай ажилладаг бол ашгаа хэрхэн зарцуулдаг вэ?	1. Илүү гарсан орлогоор хуримтлал үүсгэдэг 2. Илүү гарсан орлогоор бизнестээ хөрөнгө оруулалт хийдэг 3. Түүхий эд, бараа материалын татан авалтыг нэмэгдүүлж, үйлдвэрлэлээ нэмэгдүүлдэг 4. Өр зээлээ төлдөг 5. Ажилтнуудын цалин, урамшуулалд зарцуулдаг 6. Өрхийн хэрэглээндээ томоохон хөрөнгө оруулдаг 7. Бусад		
7	Алдагдалтай ажилладаг бол дутагдаж буй хувиа хаанаас санхүүжүүлдэг вэ?	1. Өрхийн орлогоосоо санхүүжүүлдэг 2. Зээл авдаг 3. Хөрөнгө оруулалт, тусламжаар (төсөл, хөтөлбөрийн хүрээнд) 4. Ойр дотны, хамаатан садны дэмжлэг тусламжаар 5. Зээлээр бараа, материалаа авдаг 6. Эд хөрөнгө, эд материалаа зарж борлуулдаг 7. Бусад		
8	Та бизнесийн орлогынхоо зардлын бүтцийг тодорхойлно уу?	#	ЗАРДЛЫН ТӨРӨЛ	САРЫН ДУНДАЖ ЗАРДАЛ
		1	Ашиглалтын зардал (цахилгаа, ус, интернет, түрээс)	
		2	Цалин, урамшуулал	
		3	Зээлийн эргэн төлөлт	
		4	Хуримтлал	
		5	Ажлын байрны түрээс	

		6	Тоног төхөөрөмж, технологи	
		7	Тээвэр (түлш, тээвэрлэлтийн хөлс)	
		8	Түүхий эд, бараа материал	
		9	Татвар	
		10	Бусад	
9	Танай байгууллагын хөрөнгө оруулалтын хэлбэр	1. Дотоодын хөрөнгө оруулалттай 2. Гадаадын хөрөнгө оруулалттай 3. Холимог		
10	Түүхий эд, материалаа хаанаас авдаг вэ?	1. Нийслэл хотоос 2. Гадаадаас 3. Үйл ажиллагаа эрхэлж буй аймгаасаа 4. Бусад аймгаас		
11	Танай байгууллага дараах зүйлсийг хийдэг үү?	#	ЗАРДЛЫН ТӨРӨЛ	САРЫН ДУНДАЖ ЗАРДАЛ
		1	Бизнесийн орлого, зарлага хөтөлдөг эсэх	1 2
		2	Санхүүгийн тайлан гаргадаг эсэх	1 2
		3	Ажилчдынхаа цалингаас нийгмийн даатгалын шимтгэл төлдөг эсэх	1 2
		4	НӨАТ төлөгчөөр бүртгүүлсэн эсэх	1 2
		5	Бизнесийн төсөл боловсруулан төрийн, олон улсын болон бусад байгууллагаас төсөл, хөтөлбөрт хандалт хийж байсан эсэх	1 2
		6	Байгууллагын бизнесийн данстай эсэх	1 2
		7	Үйлдвэрийн байр болон бүтээгдэхүүнээ даатгуулсан эсэх	
12	Хэрвээ та санхүүгийн тайлан гаргадаггүй бол шалтгаан нь юу вэ? Яагаад?		
13	Хэрвээ санхүүгийн тайлан гаргадаг бол хэн гаргадаг вэ?	1. Өөрөө 2. Өөрийн санхүүгийн ажилтан 3. Гэрээт санхүүгийн ажилтан 4. Танил, найз, хамаатан зэргээ гуйж 5. Бусад		
14	Танай байгууллагад санхүүгийн дэмжлэг хэр шаардлагатай байна вэ?	1. Маш их 2. Их 3. Дунд зэрэг 4. Бага 5. Маш бага		
15	Ямар төрлийн санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг хамгийн шаардлагатай байна вэ?	1. Бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүн 2. Хөрөнгө оруулалт 3. Буцалтгүй тусламж 4. Ажлын байрны дэмжлэг 5. Тоног төхөөрөмжийн дэмжлэг 6. Хэрэглээний зардлын хөнгөлөлт 7. Бусад.....		

16	Та энэхүү шаарлагатай санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэгээ ямар байгууллагаас авах хүсэлтэй байна вэ?	
17	Таны байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хамгийн их нөлөөлж байгаа гадаад хүчин зүйл юу вэ?	1. 2. 3.
18	Таны байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хамгийн их нөлөөлж байгаа дотоод хүчин зүйл юу вэ?	1. 2. 3.
БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ТАЛААРХ НӨХЦӨЛ БАЙДАЛ		
19	Сүүлийн 2 жилийн хугацаанд та зээл авах хүсэлт гаргасан уу? (Мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр)	1. Тийм 2. Үгүй (20-р асуулт руу шилжих)
20	Та зээл авах хүсэлтээ хаана гаргасан бэ? (Олон сонголттой байж болно)	1. Арилжааны банк 2. Банк бус санхүүгийн байгууллага 3. Барьцаалан зээлдүүлэх газар (ломбард) 4. Хамаарал бүхий хадгаламж, зээлийн хоршоо, нөхөрлөл 5. Хувь хүн (хүүгүй болон сараар хүү тооцдог) 6. Хувь хүн (Өдрийн хүүтэй зээл) 7. Технологи суурьтай санхүүгийн байгууллага (Финтек зээлийн апп) (ямар апп ашигладагаа нэрлэнэ үү) 8. ЖДҮГ-ын зэрэг төрөөс үзүүлэх хөнгөлөлттэй зээл 9. Олон Улсын төсөл, хөтөлбөрийн зээл 10. Бусад (тодруулна уу).....
21	Та зээлээ авч чадсан уу?	1. Тийм (23-р асуулт руу шилжих) 2. Үгүй
22	Хэрэв үгүй бол танай бизнес зээл аваагүй шалтгаан юу вэ?	1. Барьцаа, хөрөнгө байхгүй 2. Орлого хүрэлцээгүй 3. Орлогоо нотолж чадаагүй 4. Нийгмийн даатгалгүй 5. Банк, санхүүгийн байгууллагаас итгэл үзүүлээгүй 6. Бичиг баримт, харьяаллын зөрчилтэй 7. Бусад (тодруулна уу)
23	Таны бизнес ихэвчлэн ямар зорилгоор зээл авах хэрэгцээ гардаг вэ? (3 хүртэлх хариулт сонгоно)	1. Ажлын байраа өргөтгөх, худалдан авах 2. Ажлын байрны түрээс 3. Бизнесээ эхлүүлэх, эсвэл өргөжүүлэх 4. Урсгал засвар, тохижилт 5. Ажилчдын цалин, хангамж тавих 6. Татварын өр, төлбөр төлөх 7. Машин, тоног, төхөөрөмж худалдан авах 8. Түүхий эд, бараа татан авалт 9. Бизнесийн өдөр тутмын, ойр зуурын хэрэгцээг хангах 10. Бусад (тодруулна уу).....

24	Та бизнестээ зориулж ойролцоогоор хэдэн төгрөгийн зээл авсан бэ? Биет хэлбэрийн зээлийг мөнгөнд шилжүүлэн тооцно. (Сүүлийн 2 жилийн хугацаан дахь хамгийн том зээл)	1. Зээл аваагүй 2. Зээл авсан a. Зээлийн дундаж хэмжээ: b. Зээлийн дундаж хугацаа: c. Зээлийн хүү: (сарын) d. Барьцаа хөрөнгийн хэмжээ:
25	Зээл хөөцөлдөхөд гардаг зардлыг тооцож үзвэл хэчнээн төгрөгийн зардал гарах вэ? (зээлийн хүүгээс гадна зээлийн шимтгэл болон бусад бичиг баримт бүрдүүлэхэд гардаг зардлууд) төгрөг
26	ЖДБЭ зориулсан зээлийн бүтээгдэхүүнээс зээл авахад тулгарч байгаа хамгийн бэрхшээлтэй асуудал нь юу байна вэ?	1. Зээлийн хүү өндөр 2. Барьцаа хөрөнгийн шаардлага өндөр 3. Бүрдүүлэх материал их 4. Мэдлэг, мэдээлэл бага 5. Орлого нотлоход хэцүү 6. Бусад (тодруулна уу).....
27	Танай бизнесийн хувьд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахад хамгийн хүндрэлтэй шаардлагууд юу вэ? Нэрлэнэ үү?
28	Зээл авахтай холбоотой бичиг баримтуудыг бүрдүүлэхэд танд ямар хүндрэл учирдаг вэ?	1. Тавигдах шаардлагуудыг ойлгодоггүй 2. Баримт бичиг бүрдүүлэх ур чадвар дутагддаг 3. Өөрийгөө илэрхийлэх чадвар дутмаг 4. Тавигдах шаардлагын талаарх мэдээллийг олон эх сурвалжаас авах чадвар дутмаг 5. Оновчтой зээлийн бүтээгдэхүүнээ сонгож чаддаггүй 6. Хамтран зээлдэгч шаардлага хангадаггүй 7. Баримт бичиг нь албажаагүй 8. Бусад
САНХҮҮГИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЦЭЭ		
29	Та сүүлийн 2 жилийн хугацаанд бизнесийн мэдлэгээ дээшлүүлэх ямар нэгэн сургалтад хамрагдаж байсан уу?	1. Үгүй 2. Тийм (Тийм бол хаанаас зохион байгуулсан ямар чиглэлийн сургалт байсан талаар тодруулна уу)

		#	ХЭРЭГЦЭЭТ МЭДЛЭГ, УР ЧАДВАРУУД	САЙЖРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ
30	Танд бизнес эрхлэхтэй холбоотой САНХҮҮГИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА хөгжүүлэх ямар сэдвийн хэрэгцээ тулгардаг вэ? А. Өөрийн сайжруулах шаардлагатай сургалтын хэрэгцээгээ үнэлнэ үү. 5=Маш чухал 4=Чухал 3= Дунд зэрэг 2= Чухал биш 1=Огт чухал биш	1	Орлого, зарлагаа тооцох санхүүгийн бүртгэл, хөтлөх аргад суралцах	
		2	Санхүүгийн төлөвлөлт хийх, удирдах	
		3	Татварын тайлан гаргах	
		4	НДШ-ийн талаарх мэдлэг, тайлан гаргах	
		5	НӨАТ-д татвар төлөгчөөр бүртгүүлэх	
		6	Бизнес эрхлэхэд төрөөс авдаг татвар, хураамжуудын талаарх цэгцтэй мэдлэг	
		7	БЖДБ-үүдэд зориулсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл	
		8	Зээлд хамрагдахад тавигдах шаардлага, материал хэрхэн бүрдүүлэх	
		9	Эрсдэл, хямралын удирдлага	
		10	Бизнес эрхлэгчид хамтран хадгаламж, зээлийн хоршоо байгуулах тухай	
		11	Бусад санхүүгийн мэдлэг тодруулах	
31	Та дээрх САНХҮҮГИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАР олгох сургалтыг хаанаас авахыг хүсэж байна вэ?	1. Банк, санхүүгийн байгууллага 2. Татвар, нийгмийн даатгал зэрэг төрийн байгууллага 3. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвүүд 4. Санхүүгийн зөвлөх үйлчилгээгээр мэргэшсэн ментор, хувийн хэвшил 5. Олон улсын төсөл, хөтөлбөр 6. Бусад		
БИЗНЕСИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ БА COVID-19-ЫН НӨЛӨӨЛӨЛ				
32	COVID-19-ын тархалт таны бизнест ямар нөлөө үзүүлсэн бэ?	1. Маш их нөлөөлсөн 2. Нөлөөлсөн 3. Дунд зэрэг 4. Нөлөөлөөгүй 5. Огт нөлөөлөөгүй 6. Хэлж мэдэхгүй байна		
33	Та өөрийн бизнестээ COVID-19-н үеийн хямралыг давж гарахад нь чиглэсэн ямар нэгэн арга хэмжээ авсан уу? (3 хүртэл хариулт сонгоно уу?)	1. Эргэлтийн мөнгө, санхүүжилт багассан 2. Борлуулалт буурсан 3. Үйл ажиллагаа түр зогссон 4. Үйл ажиллагаа бүр зогссон, хаасан 5. Бараа материал, түүхий эд бүтээгдэхүүний олдоц муу болсон 6. Бараа материал, түүхий эд бүтээгдэхүүний үнэ өссөн 7. Үйлдвэрлэлийн хэмжээ буурсан 8. Ажилчдын цалингаа тавьж чадахгүй байна 9. Ажилчдаа халсан 10. Тоног төхөөрөмж хуучирсан, дутагдалтай 11. Мэргэжлийн сургалт, зөвлөгөөнд хамрагдах боломж хязгаарлагдсан		

<p>34</p>	<p>Та сүүлийн 2 жилийн хугацаанд бизнесийн мэдлэгээ дээшлүүлэх ямар нэгэн сургалтад хамрагдаж байсан уу?</p>	<ol style="list-style-type: none"> 1. Зарим ажилтнуудыг цомхотгосон 2. Зарим эсвэл бүх ажилтнуудын цалинг багасгасан 3. Өрхийн болон гэр бүлийн хувийн зарим хөрөнгийг зарсан 4. Бизнесийн зарим хөрөнгийг зарсан 5. Хувийн хадгаламжаа ашигласан 6. Нэмж өр, зээл тавьсан (банк эсвэл бусад байгууллагуудаас илүү их зээл авсан) 7. Бүтээгдэхүүн болон үйлчилгээний төрлөө өөрчилсөн 8. Ажилтнуудыг зайнаас ажиллуулсан 9. Борлуулалтын сувгаа өөрчилж , онлайнаар борлуулсан 10. Бусад
------------------	--	--

